



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дашинчилэн сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/136/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2023 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [Erdeneb@audit.gov.mn](mailto:Erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Анхбаяр  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Төлбөрийн акт .....	16
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.....	16
5.2 Албан шаардлага .....	16
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс:7034-2580  
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 176

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

Г  
ДАШИНЧИЛЭН СУМЫН СОЁЛЫН  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
Н.МӨНХДУЛАМ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дашинчилэн сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашинчилэн сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Соёлын тухай хууль шинэчилсэн найруулгаар батлагдаж 2022 оноос мөрдөж эхлэн, эрхлэгч, номын санч-мэдээллийн ажилтан, дуу хөгжим, бүжгийн багш, музейн ажилтны нийт 5 орон тоотойгоор сумын хүн амд соёл, урлагийн үйлчилгээг үзүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн

15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,634,850.00</b>	<b>32,774,769.66</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	13,281,919.66
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	13,281,919.66
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	13,281,919.66
31211	Төрийн сангийн харилцах	-	13,281,919.66
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	50,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	50,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	16,634,850.00	19,442,850.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	16,634,850.00	19,442,850.00
35420	Аж ахуйн материал	16,634,850.00	19,442,850.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>255,011,180.74</b>	<b>293,701,273.56</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	255,011,180.74	293,701,273.56
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	251,202,180.72	288,642,273.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	440,054,167.41	440,054,167.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	(219,571,544.97)	(228,397,597.89)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,309,161.50	70,393,361.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,106,582.16)	(27,744,196.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,169,834.00	44,949,934.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,969,378.06)	(24,354,918.06)
39209	Зам, гүүрийн байгууламж	11,770,840.00	11,770,840.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(11,245,840.00)	(11,395,840.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,478,000.00	3,053,000.00
39217	Ном	10,313,523.00	10,313,523.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,809,000.02	5,059,000.06
39301	Програм хангамж	1,000,000.00	2,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(124,999.98)	(374,999.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,934,000.00	2,934,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>271,646,030.74</b>	<b>326,476,043.22</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>271,646,030.74</b>	<b>326,476,043.22</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	271,646,030.74	326,476,043.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	109,961,074.70	109,961,074.70
51101	Өмч:- төрийн	109,961,074.70	109,961,074.70
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(210,758,307.18)	(155,928,294.70)
51210	Өмнөх үеийн үр дүн	(187,042,534.58)	(210,758,307.18)
51220	Тайлант үеийн үр дүн	(23,715,772.60)	54,830,012.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	372,443,263.22	372,443,263.22
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>271,646,030.74</b>	<b>326,476,043.22</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>112,255,900.00</b>	<b>170,935,240.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>587,500.00</b>	<b>46,386,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	587,500.00	46,386,200.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	587,500.00	46,386,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	499,500.00	2,570,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	88,000.00	43,815,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>111,668,400.00</b>	<b>124,549,040.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	91,323,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	91,323,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	100,000.00	500,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	100,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	111,568,400.00	32,725,440.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	111,568,400.00	32,725,440.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>127,884,992.60</b>	<b>110,513,727.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>127,884,992.60</b>	<b>110,513,727.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	113,765,218.15	109,763,704.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	58,212,045.00	51,374,650.00
210101	Үндсэн цалин	43,709,208.00	44,765,927.00
210102	Нэмэгдэл	14,502,837.00	5,966,441.00
210104	Урамшуулал	-	642,282.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,437,505.55	6,288,583.17
210201	Тэтгэврийн даатгал	5,231,432.43	4,366,845.37
210202	Тэтгэмжийн даатгал	582,365.72	513,746.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	465,892.08	410,997.16
210204	Ажилгүйдлийн даатгал	105,255.64	90,635.86
210205	Эрүүл мэндийн даатгал	1,052,559.68	906,358.28
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	28,753,337.00	28,904,640.00
210301	Гэрэл, цахилгаан	490,487.00	641,790.00
210302	Түлш, халаалт	28,262,850.00	28,262,850.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,460,800.00	1,292,320.00
210401	Бичиг хэрэг	245,400.00	149,500.00
210402	Тээвэр, шатахуун	240,000.00	274,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	885,400.00	778,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	89,920.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	240,000.00	225,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	40,000.00	-
210604	Урсгал засвар	200,000.00	225,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	142,000.00	212,000.00
210702	Дотоод албан томилолт	142,000.00	212,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	897,838.00	4,214,804.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	897,838.00	4,214,804.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	16,621,692.60	17,251,707.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,621,692.60	17,249,207.18
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	14,119,774.45	750,023.17
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,215,600.00	750,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,015,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	750,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,904,174.45	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,904,174.45	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	23.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	23.17
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(15,629,092.60)</b>	<b>60,421,512.48</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	8,086,680.00	5,591,500.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,086,680.00	5,591,500.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(8,086,680.00)</b>	<b>(5,591,500.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(23,715,772.60)</b>	<b>54,830,012.48</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>112,167,900.00</b>	<b>127,119,540.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>499,500.00</b>	<b>2,570,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	499,500.00	2,570,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	499,500.00	2,570,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	499,500.00	2,570,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>111,668,400.00</b>	<b>124,549,040.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	91,323,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	91,323,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	100,000.00	500,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	100,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	111,568,400.00	32,725,440.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	111,568,400.00	32,725,440.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>111,167,900.00</b>	<b>113,837,620.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>111,167,900.00</b>	<b>113,837,620.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>97,048,125.55</b>	<b>113,087,597.17</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	58,212,045.00	51,424,650.00
210101	Үндсэн цалин	43,709,208.00	44,815,927.00
210102	Нэмэгдэл	14,502,837.00	5,966,441.00
210104	Урамшуулал	-	642,282.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,437,505.55	6,288,583.17
210201	Тэтгэврийн даатгал	5,231,432.43	4,366,845.37
210202	Тэтгэмжийн даатгал	582,365.72	513,746.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	465,892.08	410,997.16
210204	Ажилгүйдлийн даатгал	105,255.64	90,635.86
210205	Эрүүл мэндийн даатгал	1,052,559.68	906,358.28
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	28,753,337.00	28,904,640.00
210301	Гэрэл, цахилгаан	490,487.00	641,790.00
210302	Түлш, халаалт	28,262,850.00	28,262,850.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,225,400.00	1,618,220.00
210401	Бичиг хэрэг	150,000.00	149,500.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	885,400.00	778,800.00
210404	Ном, хэвлэл	-	500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	89,920.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	280,000.00	1,394,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	1,094,600.00
210604	Урсгал засвар	200,000.00	300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	142,000.00	212,000.00
210702	Дотоод албан томилолт	142,000.00	212,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	997,838.00	18,756,904.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	997,838.00	18,756,904.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	4,488,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,488,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,119,774.45</b>	<b>750,023.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,215,600.00	750,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,015,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	750,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,904,174.45	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,904,174.45	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	23.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	23.17
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,000,000.00</b>	<b>13,281,919.66</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,000,000.00</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,000,000.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,000,000.00	-
223001	Бусад хөрөнгө	1,000,000.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(1,000,000.00)</b>	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	13,281,919.66

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	13,281,919.66

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	109,961,074.70	372,443,263.22	(187,042,534.58)	296,361,803.34
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,961,074.70	372,443,263.22	(187,042,534.58)	296,361,803.34
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(23,715,772.60)	(23,715,772.60)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,961,074.70	372,443,263.22	(210,758,307.18)	272,646,030.74
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	109,961,074.70	372,443,263.22	(210,758,307.18)	272,646,030.74
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,961,074.70	372,443,263.22	(210,758,307.18)	272,646,030.74
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	54,830,012.48	54,830,012.48
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,961,074.70	372,443,263.22	(155,928,294.70)	327,476,043.22

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	131,034,100.0	113,837,597.2	17,196,502.8	86.9
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	131,034,100.0	113,837,597.2	17,196,502.8	86.9
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	130,266,100.0	113,087,597.2	17,178,502.8	86.8
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	61,538,300.0	51,424,650.0	10,113,650.0	83.6
210101	Үндсэн цалин	56,549,800.0	44,815,927.0	11,733,873.0	79.3
210102	Нэмэгдэл	4,988,500.0	5,966,441.0	(977,941.0)	119.6
210104	Урамшуулал	-	642,282.0	(642,282.0)	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	9,304,700.0	6,288,583.2	3,016,116.8	67.6
210201	Тэтгэврийн даатгал	6,327,200.0	4,366,845.4	1,960,354.6	69.0
210202	Тэтгэмжийн даатгал	744,300.0	513,746.5	230,553.5	69.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	595,400.0	410,997.2	184,402.8	69.0
210204	Ажилгүйдлийн даатгал	148,900.0	90,635.9	58,264.1	60.9
210205	Эрүүл мэндийн даатгал	1,488,900.0	906,358.3	582,541.7	60.9
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,797,100.0	28,904,640.0	1,892,460.0	93.9

210301	Гэрэл, цахилгаан	600,000.0	641,790.0	(41,790.0)	107.0
210302	Түлш, халаалт	30,147,100.0	28,262,850.0	1,884,250.0	93.7
210303	Цэвэр, бохир ус	50,000.0	-	50,000.0	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,752,000.0</b>	<b>1,618,220.0</b>	<b>133,780.0</b>	<b>92.4</b>
210401	Бичиг хэрэг	150,000.0	149,500.0	500.0	99.7
210402	Тээвэр, шатахуун	100,000.0	100,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	912,000.0	778,800.0	133,200.0	85.4
210404	Ном, хэвлэл	500,000.0	500,000.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.0	89,920.0	80.0	99.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,400,000.0</b>	<b>1,394,600.0</b>	<b>5,400.0</b>	<b>99.6</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.0	1,094,600.0	5,400.0	99.5
210604	Урсгал засвар	300,000.0	300,000.0	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>214,000.0</b>	<b>212,000.0</b>	<b>2,000.0</b>	<b>99.1</b>
210702	Дотоод албан томилолт	214,000.0	212,000.0	2,000.0	99.1
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,760,000.0</b>	<b>18,756,904.0</b>	<b>3,096.0</b>	<b>100.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,760,000.0	18,756,904.0	3,096.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,500,000.0</b>	<b>4,488,000.0</b>	<b>2,012,000.0</b>	<b>69.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,500,000.0	4,488,000.0	2,012,000.0	69.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>768,000.0</b>	<b>750,000.0</b>	<b>18,000.0</b>	<b>97.7</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>768,000.0</b>	<b>750,000.0</b>	<b>18,000.0</b>	<b>97.7</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.0	750,000.0	18,000.0	97.7
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>130,941,500.0</b>	<b>126,619,540.0</b>	<b>4,321,960.0</b>	<b>96.7</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>91,323,600.0</b>	<b>91,323,600.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	91,323,600.0	91,323,600.0	-	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>34,617,900.0</b>	<b>32,725,440.0</b>	<b>1,892,460.0</b>	<b>94.5</b>
132001	Орон нутгийн төсвөөс	34,617,900.0	32,725,440.0	1,892,460.0	94.5
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>5,000,000.0</b>	<b>2,570,500.0</b>	<b>2,429,500.0</b>	<b>51.4</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500,000.0	2,570,500.0	1,929,500.0	57.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.0	500,000.0	-	100.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>13,281,919.7</b>	<b>(13,281,919.7)</b>	<b>-</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0

<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	6	5	1	83.3
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	3	2	1	66.7
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	6	5	1	83.3
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1	-	100.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5	4	1	80.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансыг ашиглаагүй болно.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрхэм зорилгоо “Соёлын биет болон биет бус өв уламжлалыг өвлүүлэн түгээж, ардын уламжлал урлагийг орчин үеийн төрөл зүйлтэй хослуулан хөгжүүлж, эх хэл түүх соёлоороо бахархах, үндэсний өвөө өвлөн эзэмших, иргэнийг төлөвшүүлэн соёлын бүтээлч үйлдвэрлэл дэмжин, соёлын боловсролыг дээшлүүлэн хөгжүүлэх” гэж тодорхойлжээ.

Соёлын хэрэгцээг эрхэмлэн дээдэлж үнэт зүйлсээс суралцан, өвлөн уламжлан, бүтээж туурвин, зааж сурган түгээн дэлгэрүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Сумын түүх, соёлын өв, түүнийг өвлөн уламжлагч, хүн амын уламжлалт ёс заншил, зан үйл, байгаль цаг уур, бүтээн байгуулалтын онцлогтой холбоотой “Бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, байнга баяжуулан, иргэдийн танин мэдэхүй, соёл урлагийн авьяас чадварын түвшнийг дээшлүүлэх үндсэн үйл ажиллагааг номын санч-мэдээллийн ажилтан, дуу хөгжим, бүжгийн багш, музейн ажилтан, нягтлан бодогч нийт 6 орон тоотойгоор төрийн үйлчилгээг үзүүлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Дашинчилэн сумын соёлын төв нь Соёлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудыг үйл ажиллагаандаа мөрддөг байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дашинчилэн сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дашинчилэн сумын соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Соёлын яамны бодлогын баримт бичиг батлагдаагүйгээс, Орон нутгийн байгууллагуудын мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 337,825.0 мянган төгрөгөөр буюу 57.7 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	13,281.9	(13,281.9)
Авлага	-	50.0	(50.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	16,634.9	19,442.9	(2,808.0)
Үндсэн хөрөнгө	255,011.2	293,701.3	(38,690.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>271,646.0</b>	<b>326,476.0</b>	<b>(54,830.0)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>271,646.0</b>	<b>326,476.0</b>	<b>(54,830.0)</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>271,646.0</b>	<b>326,476.0</b>	<b>(54,830.0)</b>

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан данс нь мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд өссөн байна.

Бараа материал, үндсэн хөрөнгийн данс өссөн шалтгаан нь үнэ төлбөргүй бараа аж ахуйн материал, Соёл үйлчилгээний газраас зөөврийн компьютер, ОНХС-аас лед дэлгэц, сургалтын болон харвааны нум сумыг орлогод авснаас нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 35,000.0 мянга, улсын төсвөөс 93,215.4 мянга, өөрийн орлогоос 5,000.0 мянган төгрөг нийт 133,215.4 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 2,273.9 мянган төгрөгөөр бууруулж, өөрийн орлогоос 5,000.0 мянга, улсын төсвөөс 91,323.6 мянга, орон нутгийн төсвөөс 34,617.9 мянган төгрөг нийт 130,941.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийг тодотгоогүй байна. 2022 онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 120,353.1 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 91,323.6 мянга, орон нутгийн төсвөөс 32,725.4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 500.0 мянган төгрөгийг аймгийн Соёл, урлагийн газраас, 2,570.5 мянган төгрөгийн өөрийн орлогыг бүрдүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 113,837.6 мянган төгрөг буюу 86.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 17,196.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Соёл урлагийн газрын санхүүжилтийг номын сангийн номын баяжилтад 300.0 мянга, тохижилтод 200.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган

төгрөгөөр/

Д/Д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл т
	Код	Хөтөлбөр арга хэмжээ				
<b>Нийт дүн</b>			<b>130,941.5</b>	<b>113,837.6</b>	<b>17,103.9</b>	86.9

1	71702	80101	87,555.6	74,293.0	13,262.6	84.9
2		80111	31,097.1	29,204.6	1,892.5	93.9
3		80112	3,520.8	3,520.8	-	100.0
4		80214	3,000.0	2,999.2	0.8	100.0
5		80802	768.0	750.0	18.0	97.7
6		83603	5,000.0	3,070.0	1,930.0	61.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Рашаант сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Дашинчилэн сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 130,941.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,964.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,473.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5-д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс бүх мэдээллийг хуулийн хүрээнд хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 13 дугаар албан тоотоор ирүүлсэн.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	1,251.9	2	1,251.9	100.0
Зөвлөмж	1	772.2	1	772.2	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>2,024.1</b>	<b>3</b>	<b>2,024.1</b>	<b>100.0</b>

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд дурдсан зүйлсийг шийдвэрлэсэн байдал зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 298.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 298.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардалтай холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Илрүүлэлт:** Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу нийт 298.8 мянган төгрөгийн нэг и-баримтгүй гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Бэлтгэн нийлүүлэгч талын борлуулалтын орлогыг баталгаажуулан и-баримтыг тухай бүр шаардаж, төлбөрийн баримтыг авч хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны	Тоо	Дүн
Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу монгол шуудан болон иргэн, ААН-тэй холбоотой нэг ажил гүйлгээг и-баримтгүй гүйлгээ хийгдсэн.	1	298.8	-	-	-	-	1	298.8	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>298.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>298.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>